МОНГОЛ УЛСЫН НЭГДҮГЭЭР ЭМ ЗҮЙЧ



1980 он Прага хот.

Миний ээж Зоозонгийн Айлаахүү нь АУДС-ийн эм найруулгын факультетэд 1961 онд элсэн суралцаж, 1966 онд төгсөхдөө №1 дугаарын дипломын эзэн болсон манай улсын анхны эм зүйч билээ.

З.Айлаахүү нь 1943 оны 1 дүгээр сарын 11–д Завхан аймгийн Жавхлант хотын төвийн эмнэлэгт төрж, эцэг эхийн гар дээр хүмүүжиж байгаад бага, дунд сургуулиа амжилттай төгссөн ба 1961 онд Монгол улсад анх удаа Анагаах Ухааны Дээд Сургуульд Эмзүйн анги нээгдэж, дээд мэргэжлийн эм зүйч бэлтгэж эхлэхэд анхны оюутны нэг болон элсэж, 1966 онд гучин хоёулаа төгсжээ.

Тэр үед АУДС өөрийн гэсэн хичээлийн байргүй байсан тул МУИС-ийн дугуй заал, Эдийн засгийн дээд сургуулийн хичээлийн танхимд очин хичээллэж, хотын төвөөс зүүн зүгт байрлах Нян судлалын институт, хотын баруун урд байрлах Эмийн үйлдвэр гээд өдрийн 8 цагийн хичээлээ 2-3 газар дамжин хийхдээ сургуулийнхаа ГАЗ-51 машинд сууж явдаг байсан тухайгаа, намар сангийн аж ахуйд ургац хураах, ногооны зоорь ухах гээд л бүтээн байгуулалтын ажилд оролцдог байсан тухайгаа дурсан ярьж хөөрөлддөг байсан даа



1977 он. Хөвсгөл аймаг Нэгдсэн эмнэлэг.



ДИПЛОМ

№ 1

Үүнийг үзүүлэгч нөхөр З. Айлаахүү бол Б. Н. М. А. Улсын Анагаах ухааны Дээд сургуулийн Эм найруулгын факультетэд 1961 онд ЫСЭН суралцаад 1966 онд Анагаах Ухааны ДЭЭД мэргэжлийн бүрэн курсийг төгссөн учир Улсын шалгалтын комиссын 1966 оны 7 р сарын 1 ны өдрийн шийдвэрээр Эм най Рүүлгач мэргэжил олгов.

УЛСЫН ШАЛГАЛТЫН КОМИССЫН ДАРГА
ЗАХИРАЛ
НАРИЙН БИЧГИЙН ДАРГА

Бүртгэлийн №782

Улаанбаатар хот
1966 оны 7 р сарын ны өдөр

АУДС. Эм найруулгын мэргэжлийн диплом №1

Эм зүйн дээд мэргэжилтэн бэлтгэх оюутны хичээлийн бэлтгэл, гарын авлага, дадлага ажлын бэлтгэл хангахад эм зүйн ухааны доктор, профессор,ангийнх нь багш С.Хандсүрэн, лаборант н.Лхам, н.Хандаа нарыгаа зав чөлөөгүй хөдөлмөрлөдөг байсан тухай дурсан ярьдаг байв.

Ажил хөдөлмөрийнхөө гарааг 1966 оны 07 дугаар сард Эмийн үйлдвэрийн Гален цехэд мастерын ажил хүлээн авснаар эхэлсэн. Тэр үеэс хойш эзэмшсэн мэдлэг боловсролоо байнга дээшлүүлж, шинэ мэдээлэл олж авах, эвсэг ажилч хичээнгүй хамт олныг бүрдүүлэх, хөдөлмөр зохион байгуулалт хөнгөвчлөхөд анхааран ажилладаг байжээ. Тухайлбал: 25 дугаар эмийн санд нэрмэл ус дамжуулах ган хоолойг эм найруулагчийн өрөө рүү оруулсан нь тухайн үедээ эм найруулах технологи, хөдөлмөр зохион байгуулалтын талаас ажил хөнгөвчилсөн шинэ санаачлага болон сайшаагдаж, хэд хэдэн эмийн сангуудад уг туршлагыг нэвтрүүлжээ.

Ээж маань УБТЗ-ын Эмнэлгийн эмийн сангийн эрхлэгч, мэргэжилтнээр ажиллаж байхдаа тус эмнэлэгт ажиллаж байсан орос мэргэжилтнүүдээс их зүйлийг сурч, мэдэж, өөрийгөө хөгжүүлж, МАХН –ын гишүүнээр элсэж, 2 өрөө шинэ орон сууцанд орж байжээ.

Гэр бүлийн хамт МАХН–ын Төв хорооны шийдвэрээр Хөвсгөл, Өвөрхангай аймгуудад томилогдон ажиллах хугацаандаа Хөвсгөл аймгийн Нэгдсэн эмнэлгийн Эмийн сангийн эрхлэгчээр 10 жил, Өвөрхангай аймгийн эмийн сангуудын удирдах конторын эмийн хэрэгцээ, судалгаа мэдээллийн байцаагчаар 5 жил тус тус ажилласан. Тухайн үед орон нутагт тарилгын бүх төрлийн эм дутагдалтай, ялангуяа судсаар тарих, сэлбэх, хордлого тайлах, шокоос гаргах шингэн чухал шаардлагатай байсан тэр жилүүдэд ээж маань өөрийн санаачлагаар 40 орчим нэрийн тарилгын эм, шингэн бэлтгэж байсан нь эмчилгээнд үр дүнгээ өгч, эмнэлгийн зүгээс талархал хүлээн олон хүний амь насыг аварч чадсан юм. Өвөрхангай аймагт эмийн мэдээлэл, сурталчилгааны кабинет, номын санг шинээр байгуулсан нь эмч, эм зүйчдийн мэргэжил дээшлүүлэх сургалтын төв болон өргөжиж, улмаар онол практикийн бага хурал, лекц, сонсгол-мэдээлэл сурталчилгаа хийх, гарын авлага бэлтгэн гаргах, эм эмнэлгийн хэрэгслийн үзэсгэлэн худалдааг зохион байгуулах зэрэг ажлуудыг хийдэг төв болсон тухай тэмдэглэгдэн үлдсэн байдаг.

1991 онд Улаанбаатар хотод шилжин ирж, Монгол эмнэлэг сувиллын төвд эмийн мэргэжилтнээр

ажиллахдаа маарамба н.Санжаажав, н.Гончиг, н.Дагва, н.Дамдин, н.Оросоо, АУДС-ийн багш н.Хүрэлчулуун, дэд доктор н.Лигаа нараар багшлуулан, монгол эм, тан бэлтгэх курст суралцан төгсөж, монгол эм, тан, европ эм бэлтгэх эмийн санг байгуулах зорилтыг амжилттай хэрэгжүүлсэн. Эмийн ургамал түүж, түүхий эд бэлтгэн 80 орчим нэрийн монгол эмийн жорыг бэлтгэсэн нь эмчилгээнд одоо хүртэл ашиглагдаж байна.

Ээжийн минь хөдөлмөрийг төр засгаас өндрөөр үнэлж, эрүүлийг хамгаалахын тэргүүний ажилтан, эм зүйн тэргүүний ажилтан, төрийн дээд шагнал Алтангадас одон, ойн медалиудаар шагнасан юм.

Эм судлалын тэнхимийн 70 жилийн ойг тохиолдуулан үе үеийн эм зүйч нарт баярын мэнд дэвшүүлж, ажил хөдөлмөрт нь өндөр амжилт, эрдэм судлалын ажилд нь өндөр амжилтыг хүсэн ерөөе!

Эм зүйн анхдагч болсон ээжийн минь ангийн хамт олонд эрүүл энх, урт удаан наслахыг хүсэн ерөөе!
Хайрт ээжийнхээ гэгээн дурсгалд зориулав.
Ум сайн амгалан болтугай.

Охин, хүүхдийн мэдрэлийн эмч, АУ-ны магистр, клиникийн профессор Н.Уганцэцэг



1966 он. АУДС-ийн Эмийн анхдугаар төгсөлт